



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/10

Эрдэнэт


**Орон тооны бус зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйл, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/1416 дугаар албан бичгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хэрэглэгчдэд бараа, ажил, үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл олж авах, хэрэглээний соёл эзэмших сургалт мэдээллийг мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран явуулж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллан, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг орон тооны бус зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ээлжит XII хуралдааны 12/10 дүгээр тогтоолын хавсралт



**ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга:** - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
- Гишүүд:**
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
 - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
 - Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Орхон аймаг дахь танхимын тэргүүн
 - Орхон аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга
 - Орхон аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
- Нарийн бичиг:** - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Орхон аймаг дахь байцаагч